



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 1127

Мандлговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "д", Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн төвд шинээр баригдах дулааны станцын техник эдийн засгийн үзүүлэлт, зураг төсвийг боловсруулах ажилд мэдээлэл, судалгаагаар хангаж, хамтран ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Мөнхчулуун	/Аймгийн Засаг даргын орлогч/
Нарийн бичгийн дарга:	О.Мөнхзул	/Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн/
Гишүүд:	Н.Эрдэнэ-Очир	/Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга/
	Э.Чагнаадорж	/Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга/
	Н.Гантулга	/Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга/
	Б.Золжаргал	/Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч/

Хоёр. Дулааны станцын техник эдийн засгийн үзүүлэлт, зураг төсвийг боловсруулах ажилд холбоотой мэдээлэл, судалгаагаар гүйцэтгэгчидтэй хамтарч ажиллахыг ажлын хэсэг /Ж.Мөнхчулуун/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200096

